



L3605/G9191 : MON48076 - ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

АЖЛЫН ДААЛГАВАР

С10 - БАРИЛГЫН АЖЛЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ, ТӨСӨВ, БАРИЛГЫН АЖЛЫН ХЯНАЛТ ТАВИХАД ЗАХИАЛАГЧИД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

А. ТАНИЛЦУУЛГА

Азийн Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээлээр Монгол Улсын Засгийн газар (Зээлийн дугаар 3605) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл” (цаашид “Төсөл” гэх)-ийг хэрэгжүүлж байна. Тус төсөл нь Улаанбаатар хот болон аймгуудын түвшинд ХБИ-дэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, ХБИ-ийн бие даан амьдрах чадварыг дээшлүүлж, нийгэм, эдийн засагт тэдний оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхийн тулд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой юм. Холбогдох мэдээллийг доорх линкнээс үзнэ үү.

<https://www.adb.org/sites/default/files/project-documents/48076/48076-002-rrp-en.pdf>

Төслийн хүрээнд Дорнод, Ховд, Дархан-Уул, Архангай, Хөвсгөл болон Дундговь аймгуудад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан Хөгжлийн төв, Улаанбаатар хотод Хөдөлмөр эрхлэлтийн төвийн барилга баригдана. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам төслийн барилгын ажлын нарийвчилсан зураг, төсөв боловсруулах барилгын компанийг шалгаруулж, ажлыг эхлүүлсэн.

Зөвлөх нь С1 багцын ажлыг гүйцэтгэх барилгын компанийн бүтээгдэхүүн нийлүүлэлтэд хяналт тавихад төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Төсөл хэрэгжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх, барилгын зургийн явцад хэрэгжүүлэгч байгууллага болон барилгын зургийн компанийг зохицуулалтаар хангана.

Б. ЗӨВЛӨХ АЖЛЫН ЗОРИЛТУУД

1. Газрын зөвшөөрөл, байршил, халаалт, сантехник, механик болон цахилгааны зөвшөөрөл зэрэг барилга барих зөвшөөрлийг цаг хугацаанд авахад төсөл хэрэгжүүлэгч байгууллагад дэмжлэг үзүүлэх.
2. Барилгын зургийн ажлын явцад Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын ерөнхий газар болон аймгуудын Засаг Даргын Тамгын Газар, эрүүл мэнд, аюулгүй байдал болон галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж төсөл хэрэгжүүлэгч байгууллагад дэмжлэг үзүүлэх.
3. Аймаг тус бүрд хийгдсэн барилгын зургийн бүрэн бүтэн байдал, гүйцэтгэл, чанарыг шалгах, Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын өмнөөс Ажлын даалгавар болон гэрээнд заасны дагуу бүтээгдэхүүний жагсаалтын дагуу барилгын зураг, өртгийг тооцооллын үнэн зөв байдлыг шалгах, холбогдох байгууллагуудаас өгсөн

засвар, шаардлагыг барилгын эцсийн зурагт тусгасан байдлыг хянах, баталгаажуулах.

4. Түгээмэл загварын зарчим, Барилгын тухай хууль, Чанарын менежментийн стандарт MNS болон Монгол улсын холбогдох хууль тогтоомж, журам, гэрээний баримт бичигт тусгасан бусад стандартад нийцүүлэн зургийн гүйцэтгэл хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих, төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон ТХН-д дэмжлэг үзүүлэх.
5. Барилгын зураг боловсруулах зургийн компаниас аймаг тус бүрд хийгдэж байгаа ажлын явцыг төсөл хэрэгжүүлэгч байгууллагад тайлагнах.
6. Барилгын зураг боловсруулах зургийн компанийн ажлын төлөвлөгөө болон хуваарийн дагуу бүтээгдэхүүн нийлүүлэлтэд хяналт тавих, төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон ТХН-д дэмжлэг үзүүлэх.
7. Шаардлагатай бол сэргээн босголтын үнэлгээг хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэх байгууллагад дэмжлэг үзүүлэх, барилгын ажлыг эхлүүлэх, эхлүүлэх үйл явцын бэлэн, бүрэн байдлыг хангах.

В. БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭЛТ

Зөвлөх нь ажилласан сар бүрийн эцэст ажлын явцын тайланг ирүүлнэ. Тайлан нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Зургийн компанийн ажлын төлөвлөгөө болон бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу аймаг тус бүрийн барилгын зургийн ажлын явц
- Талбайн хяналтыг зургаар баталгаажуулах
- Тулгарч буй асуудлууд, шийдлийн хамт
- Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон зургийн компанид өгсөн зөвлөмж болон түүний биелэлтийн тухай